57

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.08.02 № 08

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Компаниудын дансыг битүүмжилж
буй үйл ажиллагааны талаар

Улсын Их хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс нийгмийн салбар бүрийн төлөөлөлтэй тогтмол уулзалдаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэх, түүний шийдлийг эрэн хайх уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж байна. Энэ уулзалтын үеэр бизнес эрхлэгчид өөрсдийн өмнө тулгамдаж буй олон асуудлуудыг нэрлэн тоочиж буйн нэг нь компани, аж ахуйн нэгжийн дансыг битүүмжлэн хааж буй асуудлыг нэрлэж буй билээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлд зааснаар аж ахуйн нэгжийн дансыг битүүмжлэх процесс, түүнтэй холбоотой хууль эрх зүйн актуудын талаар;

2.Сүүлийн 10 жилийн хугацаанд дансаа битүүмжлүүлсэн аж ахуйн нэгжийн битүүмжлэгдсэн дансны мөнгөн дүнгийн статистик мэдээллийн талаар;

3.Уг процесстой холбогдох харилцааг цаашид хэрхэн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжид эрсдэл багатайгаар шийдвэрлэж болох тухай шийдэл, авах арга хэмжээний талаар зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ

20240027